



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 57

Есөнбулаг сум

Цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх  
иргэдийн тооны хязгаар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар бүлгийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 79 дүгээр тогтоол, Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмын 1 дэх хэсгийн 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус аймгаас 2018 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тоог 40 хүнээр тогтоож хавсралтаар баталсугай.

2. “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ыг үндэслэн иргэдийг элсүүлэх, цугларалт, сургалт явуулах, орон нутгийн бүтээн байгуулалтын ажил болон гамшгаас хамгаалах, хил хамгаалалтад туслах, хүмүүнлэгийн үйл ажиллагаа, онцгой нөхцөл байдлын үед дайчлах зэрэг үйл ажиллагаанд татан оролцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Цэргийн штаб /хурандаа Ц.Буянжаргал/ нарт даалгасугай.

3. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг элсүүлэх ажлыг ил тод нээлттэй зохион байгуулж, иргэд олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д үүрэг болгосугай


ДАРГА



Т.ГАНЗОРИГ

0000153

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2018 оны 06 дугаар сарын 21 -ний өдрийн  
57 дугаар тогтоолын хавсралт



Говь-Алтай аймгаас 2018 онд дүйцүүлэх  
албанд хамрагдах иргэдийн тооны хязгаар

Д/д	Сум	Хамрагдах хүний тоо
1.	Алтай	1
2.	Баян-Уул	4
3.	Бугат	1
4.	Бигэр	2
5.	Дарив	2
6.	Дэлгэр	3
7.	Жаргалан	2
8.	Тонхил	1
9.	Төгрөг	3
10.	Тайшир	1
11.	Хөхморьт	2
12.	Чандмань	5
13.	Эрдэнэ	4
14.	Есөнбулаг	9
	Бүгд	40

---oOo---